

## Төслийн нэр: Эрдэм-эх хэлээс эхтэй

### Хэсэг I: Сургуулийн ерөнхий мэдээлэл

Аймаг, хот	Баян Өлгий аймаг
Сум, дүүрэг	Улаанхус сум
Сургууль, СЭЭБХ-ны хаяг	М.Зайсановын нэрэмжит бүрэн дунд сургууль
СЭЭБХ-ны Зохицуулагчийн овог, нэр	Хумарын Алтынай

### Хэсэг IIa. Нөхцөл байдлын шинжилгээ

Давуу тал	Сул тал
<ul style="list-style-type: none"> <li>Багшийн номуудаар хангагдсан, шинэ үзүүлэн таниулах болон материалуудыг багш нар өөрсдөө олж авч байна.</li> <li>Ээлжит хичээл бүрийг хүүхдийн идэвх анхаарлыг татсан, тэдэнд бие дааж сурах арга барил эзэмших бүтээлч үйл ажиллагаа болгон явуулдаг.</li> <li>Математик, байгаль ухааны хичээлүүдээр ЭЭШ-аар аймгийн түвшингээс дээгүүр шалгагдсан болно.</li> <li>Хүүхэд хөгжүүлэх сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг жилээр гарган улирал бүр судлагдахуун тус бүрээр судалгаат хичээл явуулж, багш нарын ур чадвар арга зүйг дээшлүүлж байна.</li> <li>Бага боловсролын хөтөлбөрийн хүрээнд эцэг эх, олон нийттэй байнга хамтран ажиллаж байна. Сургуулийн удирдах зөвлөл, эцэг эхийн зөвлөлөөс сургуулийн үйл ажиллагаанд дэмжлэг тусалцаа үзүүлдэг.</li> <li>Сургууль интернетэд холбогдсон, багш нарын 65% нь интернет ашигладаг. Мөн Мобиком, юнител, жи-мобайль үүрэн телефон ашигладаг. Сургууль мэдээлэл зүйн кабинеттэй.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Улаанбаатар хотоос хүргэгдсэн зардал нэмэгдээд номын үнэ өндөр байгаа учир олон хүүхэд нь суралцдаг гэр бүлийн хүүхдүүд номоо худалдан авч чадахгүй байна. Сургалтын хэрэглэгдэхүүн дутмаг.</li> <li>Хичээлийн хэрэглэгдэхүүн, сургалтын тоног төхөөрөмжүүд дутагдаж байна.</li> <li>Монгол хэл сурах орчин байхгүй, бага ангийн багш нарын 90% нь Баян Өлгий аймгийн Багшийн коллеж төгссөн болохоор ярианы чадвар тааруу байна.</li> <li>Математик, эх хэлний хичээлүүдийн хэргэлэгдэхүүн хүрэлцэхгүй байна.</li> <li>Багш нарын онолын мэдлэг, заах арга ур чадвар харилцан адилгүй учир цаг их зарж байна.</li> <li>Эцэг эхчүүд хүүхдийн сурлага, гэрийн даалгаварт туслах боловч өөрсдөө мэддэгүй зүйл олон, бага насны хүүхэдтэй ажиллах арга зүй дутмаг</li> <li>Мэдээлэл зүйн кабинетийн компьютерүүд хуучирсан цөөхөн байгаа учраас хүртээмжгүй байна.</li> <li>Багш нарын интернет, МХТ-той ажиллах чадвар сул.</li> </ul>

Боломж	Эрсдэл
<ul style="list-style-type: none"> <li>Сургуульд кабинет, анги танхим хүрэлцээтэй</li> <li>Сургуульд мэдээлэл зүйн кабинеттэй, багш бүр компьютертой.</li> <li>Сургуулийн бүх сурагчид казах хүүхдүүд, бага ангийн сургалт казах хэлээр явагдана.</li> <li>Багш нар илүү цагаар сурагчдыг үндэсний хэлээр сургахыг илүү сонирхдог.</li> <li>Эцэг эхчүүд сурагчдын сурлагад байнга анхааралаа хандуулдаг, тусалж, дэмжиж байдаг.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Сургалтын хэрэглэгдэхүүн дутмаг</li> <li>Багш нарын компьютертой ажиллах чадвар муу, ихээнх багш нар бусад хүмүүсийн тусламж авдаг.</li> <li>Багш, сурагчид үндэсний хэлээр уран ярьж чаддаггүй, зүйр цэцэн үгийг бага хэрэглэдэг.</li> <li>Сурагчид ном уншихад цаг зав гаргаддаггүй, гар утас, интернетээр их оролддог</li> <li>Зарим эцэг эхчүүд хүүхдийн гэрийн даалгавар, сургалтанд туслах үед мэддгүй зүйл их гардаг. Сургах арга зүйгээ мэддэггүй.</li> </ul>

### Хэсэг IIб. Төслийн зорилго, зорилт, хүрэх үр дүн

### Төслийн зорилго:

Зүйр цэцэн үгийг оновчтой хэрэглэх аргыг хөгжүүлж, багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэн суралцагч, эцэг эх, багш бүрийн зөв ярих, бүтээлч сэтгэлгээ, эх хэлний чадварыг эцэг эхийн оролцоотойгоор хөгжүүлнэ.

Төслийн зорилтууд:

- Сурагчдын оюун ухааныг өөрсдийн сонирхолын дагуу хөгжүүлэх
- Зүйр цэцэн үгийг байнга хэрэглэж, ном унших сонирхолтой болно.
- Эх хэлээрээ зөв ярьж, алдаагүй бичих, эх хэлний мөн чанарыг сайжруулах
- Багш, эцэг эхчүүдийн мэдлэг чадвар, арга зүйг сайжруулах
- Багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагаа, оролцоог сайжруулна.

**Хамрах хүрээ:** Бага ангийн 410 сурагч, 20 багш, 300 агруй эцэг эх, СЭЭБХ-ны гишүүд

### Хэсэг III. Төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалт ба ажлын төлөвлөгөө

№	Төслийн үйл ажиллагаа	Хариуцах эзэн	хугацаа	Хүрэх үр дүн
1.	СЭЭБХ-ны гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, танилцуулах үйл ажиллагааг чанаржуулах	СЭЭБХ-ны удирдах зөвлөл	2019.6-р сар	СЭЭБХ-ны үйл ажиллагаа сайжирч, оролцоо нэмэгдэнэ.
2.	Төслийн нээлтийн арга хэмжээ	СЭЭБХ	2019.9-р сар	Шийдвэр гаргах түвшний хүмүүс болон эцэг эх сумын иргэдэд СЭЭБХ-ны үйл ажиллагааг таниулна.
3.	Бага ангийн бүх сурагчдаас зүйр цэцэн үгнүүдээс гарааны үнэлгээ авах.	БАЗАН	2019.9-р сар	Төсөл дууссаны дараа үнэлгээ хийж, үр дүнг тооцох үед харцуулалт хийхэд тус болно.
4.	Багш нарын монгол хэлний түвшинг тодорхойлох	БАЗАН	2019.9-р сар	Төслийн үр дүнг тооцох үед ашиглах болно.
<b>Багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх хүрээнд</b>				
5.	“Зүйр цэцэн үгийг ашиглан эх хэлний хичээлийг бүтээлчээр заах нь” арга зүйг боловсруулах	Зөвлөх баг, Монгол хэлний багш нар	2019.9-10-р сар	Багш нарт зориулсан арга зүйг боловсруулснаар бага ангийн багш нар энэ арга зүйг ашиглан эх хэлний хичээлээ заадаг болно.
6.	“Зүйр цэцэн үгийг ашиглан эх хэлний хичээлийг бүтээлчээр заах нь” арга зүйн сургалтыг бага ангийн багш нарт явуулах	Зөвлөх баг, Сургагч багш нар	2019.11-р сар	Сургалтаар багш нар арга зүйг эзэмшихээс гадна сургалтын хэрэглэгдэхүүнээ багаар ажиллаж, хамтран боловсруулна.
7.	Арга зүйг турших нээлттэй хичээл сурагчдад зааж турших	Сургалтын менежер, СЭЭБХ	2019.11-12-р сар	Нээлттэй хичээлийн үеэр зөвлөх баг сууж тэмдэглэл хөтлөх ба тэмдэглэлийн дагуу хичээлийг сайжруулах зөвлөгөөг зөвлөх багийнхан өгнө.
8.	“Зүйр цэцэн үгийг ашиглан эх хэлний хичээлийг бүтээлчээр заах нь” арга зүйн дагуу эх хэлний хичээлийг заах төлөвлөгөөг 2020-2021 оны хичээлийн жилийн төлөвлөгөөнд тусгах,	Сургалтын менежер	Хичээлийн жилийн турш	Сургалтын менежер зөвлөх багтай хамтран хичээлийн жилийн турш арга зүг эх хэлний хичээлд ашиглах, ахицыг үнэлэх хуудас боловсруулан сурагчдын ахицаас гадна багш нарын

	төлөвлөгөөний дагуу хичээл явагдаж байгаа эсэхийг хянах хуудас боловсруулах.			заах арга зүй, бүтээлч байдалд гарсан ахицыг үнэлж, 50-иас дээш хувийн ахицтай багш нарыг урамшуулна.
<b>Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх хүрээнд</b>				
9.	“Зүйр цэцэн үгийг ашиглан эх хэлний хичээлийн даалгаварыг бүтээлчээр хийлгэх нь” эцэг эхэд зориулсан арга зүйг боловсруулах	Зөвлөх баг, Монгол хэлний багш, СЭЭБХ	2019.9-10-р сар	Багш нар эцэг эхэд зориулж, арга зүйгээ хялбаршуулан боловсруулна.
10.	“Зүйр цэцэн үгийг ашиглан эх хэлний хичээлийн даалгаварыг бүтээлчээр хийлгэх нь” эцэг эхэд зориулсан арга зүйн сургалтыг эцэг эхчүүдэд зориулсан сургалтыг зохион байгуулна.	Зөвлөх баг, Монгол хэлний багш, СЭЭБХ	2019.11-р сар	1-5-р ангийн бүлэг бүрийн эцэг эх, хүүхдийнхээ нас сэтгэхүйн онцлогт тохируулан зүйр цэцэн үгийг ашиглан эх хэлний хичээлийн гэрийн даалгаварыг хийлгэх чадвартай болно. Ахицаа үнэлэх хуудсыг тогтмол бөглөж, тэмдэглэж явна.
11.	Зүйр үгийн тайлбар бүхий зурагт ном бүтээх	СЭЭБХ, БАЗАН	2019.12-р сар	Эцэг эхчүүдийг анги тус бүрээр нь багт хувааж, зурагт ном бүтээх даалгавар өгнө. Баг бүрт нэг СЭЭБХ-ны гишүүн, нэг бага ангийн багш зөвлөн туслах үүрэгтэйгээр ажиллана.
12.	Зүйр үгийн зурагт номын үзэсгэлэн гаргах	СЭЭБХ, БАЗАН	2020.1-р сар	Эцэг эхчүүдийн бүтээлээр сургуулийн хэмжээнд үзэсгэлэн гаргах ба шилдэг бүтээлийг эцэг эхчүүдийн саналаар шалгаруулж, урамшуулна.
<b>Зүйр цэцэн үгийг оновчтой хэрэглэх аргыг хөгжүүлэх, түгээх хүрээнд</b>				
13.	Зүйр цэцэн үгсүүдийг хуримтлуулж, сэдэв бүрт хуваах	Төслийн багийн гишүүд	2020.2-р сард	Арга зүйн сургалтад ашиглах зүйр үгийн сан бүрдүүлнэ.
14.	Эх хэлний гарын авлага боловсруулах.	Зөвлөх баг, Монгол хэлний багш нар	2020.3-р сард	Өмнөх хичээлийн жилд ашигласан зүйр үгийг оновчтой ашиглах арга зүй болон эцэг эхчүүдийн бүтээсэн зурагт номыг ашиглан эх хэлний гарын авлага боловсруулна. Зүйр үгийг ашиглах арга зүй гарын авлагын зөвхөн нэг хэсэг нь байх бөгөөд ардын аман зохиол, үлгэр, туульс, түүхэн бүтээлүүд нэмэлтээр ашиглаж, хүүхдэд сонирхолтой, эцэг эх ашиглах боломжтой гэрийн даалгавар хийлгэх

				боломжтой байдлаар арга зүйг боловсруулж, 2019 оны хичээлийн жилийн нэгдүгээр улиралд туршиж, сайжруулна.
15.	Эх хэлний баяр	СЭЭБХ, БАЗАН	2020.4-р сар	Эх хэлний шинэхэн арга зүйг танилцуулахын зэрэгцээ зүйр үгийг оновчтой ашиглах арга зүйг хэрэгжүүлж туршсанаар гарсан ахиц, амжилтаа үнэлнэ.  Анги бүр өөрсдийн сурч мэдсэн зүйр цэцэн үг, амжилтыг эцэг эх, сургууль хамт олондоо танилцуулах, үзэсгэлэн гаргах
16.	Төслийн хаалт	СЭЭБХ	2020 оны 4 сар	Төслөөс гаргсан үр дүнг тайлагнах, ач холбогдолыг ойлгуулж, цаашид үргэллүүлэн хэрэгжүүлэх. Аймаг сумын удирдлагуудыг урьж оролцуулна.

#### Хэсэг IV Зардлын задаргаа.

Зардлын нэр	Хэмж их нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хүрэх үр дүн
Төслийн нээлт хаалтын зардал	Удаа	2	80 000	160 000	Шийдвэр гаргах түвшний хүмүүс болон эцэг эх сумын иргэдэд СЭЭБХ-ны үйл ажиллагааг таниулна.
Зөвлөх багийн урамшуулал Аймгийн Монгол хэлний шилдэг багш, бага ангийн шилдэг багш нараас багийг бүрдүүлэх	Хүн	3	250 000	750 000	Зүйр цэцэн үгийг ашиглан эх хэлний хичээлийг бүтээлчээр заах арга зүйг боловсруулна.  Зөвлөх багт СЭЭБХ-ны төлөөлөл болон сургуулийн бага ангийн багш нарын төлөөлөл оролцоно.
Зөвлөх багийн унааны зардал	Хүн	3	100 000	300 000	Төслийн хугацаанд аймгийн төвөөс 3-4 удаа ирнэ.
Зүйр цэцэн үгийг ашиглан эх хэлний хичээлийг бүтээлчээр заах арга зүйг боловсруулах уулзалт	Удаа	5	30 000	150 000	Арга зүй боловсруулах багийн гишүүд уулзаж, арга зүйгээ ярилцаж, сайжруулна.
Арга зүйг турших нээлттэй хичээлийг зохион байгуулах 1-5р ангийн бүлэг бүрээс нэг ангийн сонгож хийнэ.	Удаа	5	50 000	250 000	Нээлттэй хичээлийн үеэр зөвлөх баг сууж тэмдэглэл хөтлөх ба тэмдэглэлийн дагуу хичээлийг сайжруулах зөвлөгөөг зөвлөх багийнхан өгнө.

“Зүйр цэцэн үгийг ашиглан эх хэлний хичээлийн даалгаварыг бүтээлчээр хийлгэх нь” арга зүйг боловсруулах уулзалт	Удаа	3	30 000	90 000	Зөвлөх баг болон эцэг эхийн төлөөллүүд хамтран ажиллаж энэхүү аргачлалыг боловсруулна.
“Зүйр цэцэн үгийг ашиглан эх хэлний хичээлийн даалгаварыг бүтээлчээр хийлгэх нь” арга зүйн сургалт	Удаа	2	100 000	200 000	Ангий бүрээс 5 эцэг эх сургалтад хамруулах ба 120 эцэг эхийг 2 хувааж арга зүйн сургалтыг явуулна. Сургалтад хамрагдсан эцэг эхийн төлөөлөл ангийн багштайгаа хамтран ангийн хурлаар бусад эцэг эхдээ хичээлийг заана.
Зүйр үгийн тайлбар бүхий зурагт ном бүтээх	анги	25	20 000	500 000	Анги бүрт гарын доорх материалыг ашиглан ном бүтээх даалгавар өгөх ба ном бүтээхэд шаардлагатай ватум цаас, цавуу, хайч гэх мэт зүйлсийг СЭЭБХ худалдан авч өгнө.
Зүйр үгийн зурагт номоор үзэсгэлэн гаргах	Удаа	1	150 000	150 000	Сургууль дээр эцэг эхчүүдийн бүтээл үзэсгэлэн гаргах ба хамгийн ойлгомжтой, удаан ашиглах ном бүтээсэн эцэг эхийг урамшуулна. Үзэсгэлэнгийн үеэр багш, хүүхдүүдээс санал хураах боломжийг бүрдүүлж, хамгийн олон санал авсан бүтээлийг шалгаруулна.
Эх хэлний гарын авлага боловсруулах багийн урамшуулал 1-р дэвтэр – багш нарт зориулсан 2-р дэвтэр эцэг эхэд зориулсан	Хүн	4	200 000	800 000	2 эцэг эх, 2 багш энэ багт ажиллах ба өмнөх зөвлөх багаас 2 багш нь ажиллана.
Эх хэлний гарын авлага хэвлэх 1-р дэвтэр – багш нарт зориулсан 2-р дэвтэр эцэг эхэд зориулсан	Ш	450	1000	450 000	Багш нарын тоогоор болон эцэг эхчүүдэд хүртээмжтэй ашиглах боломжтойгоор хэвлэнэ.
Эх хэлний баяр	удаа	1	200 000	200 000	Эх хэлний гарын авлагыг танилцуулах, төслийн хугацаанд зүйр үгийг ашиглах арга зүйг хамгийн сайн ашигласан гэр бүл, анги, сурагчийг шалгаруулж алдаршуулна.
Казах хэл дээр бичигдсэн үлгэр, домог, зүйр үг зэргийг багтаасан номыг худалдан авна.	Ш	20	10 000	200 000	
Принтер	Ш	1	500 000	500 000	
Принтерийн хор	Ш	4	30 000	120 000	

Харилцаа холбооны зардал	Сар	10	20 000	200 000	
Бичиг хэргийн зардал	Улирал	4	60 000	240 000	
Унааны зардал				52 000	
Банкны шимтгэл				20 000	
<b>Бүгд</b>				<b>5 332 000₮</b>	

#### **Хэсэг VI Төслийн тогтвортой байдал**

- Сургалтын чанараа сайжируулж, багш нар бие-биенээс суралцах болно.
- Хүүхэд бүрийн сурах сонирхол, идэвхи чармайлалт нэмэгдэнэ
- Багш нарын мэдлэг чадварт ахиц гарна.
- Сурагчдын эх хэлээрээ зөв бичиж, унших чадвар сайжирна.
- Хамгийн олон зүйр үг хэрэглэдэг сургууль болж, бусад сургуулиудад туршлагаас хуваалцах болно.
- Багш, сурагч, эцэг эхчүүд зүйр цэцэн үгийн сантай болж, эх хэлээ хайрлана.
- Сумын бүх ард түмэн зүйр цэцэн үгийн мөн чанарыг ойлгож, өдөр тутмын ярианд байнга хэрэглэх болно.
- Хичээлийн үйл явц сонирхолтой болно.
- Эцэг эх, олон нийтийн оролцоо сайжирна.

Төслийн саналыг дэмжсэн гишүүдийн гарын үсэг, нэр:

СЭЭБХ-ны Зохицуулагч: Нэр...*Х. Аюултөв*... Гарын үсэг...*Х. Аюултөв*...

Төслийг боловсруулсан:	Эцэг эх / Нэр	<i>З.Бердиген</i>	Огноо: 2018он 12-р сарын 08 өдөр СЭЭБХ-ийн ЭЦЭГ ЭХ, БАГШ ИЙН ХОЛБОО НУТББ Б317254529 8201345 ГТТ5985
	Эцэг эх / Нэр	<i>С.М.М.</i>	
	Эцэг эх / Нэр	<i>З.Бердиген</i>	
	Багш / Нэр	<i>З.Бердиген</i>	
	Багш / Нэр	<i>М. Худман</i>	
	Багш / Нэр	<i>М. Худман</i>	
Гарын үсэг	<i>З.Бердиген</i>	<i>З.Бердиген</i>	